

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2009 ОНЫ 01 ТООТ ТОГТООЛООР
 БАТЛАГДСАН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
 АРГА ХЭМЖЭЭНД АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ ХАРИУЦУУЛСАН
 АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

2010.03.29

Баянхонгор

Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт			
Хяналтад авсан нийт тоо		91	
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо			
Үүнээс	Биелсэн /100%/		
	Хэрэгжих шатандаа		
	Үүний дотор	90%	
		70%	5
		50%	
		30%	69
		10%	10
	Тасарсан		7
	2009 оны хэрэгжилт		126.3%
	Дөрвөн жилийн мөрийн хөтөлбөрийн х□□□□□□□□□□ □□□□□□ □□□□: 30,9%		

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
 ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ
 ТАСГИЙН ДАРГА

М.ӨНӨРЖАРГАЛ

ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ч.ГОМБОДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2009 ОНЫ 01 ТООТ ТОГТООЛООР
БАТЛАГДСАН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНД АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ ХАРИУЦУУЛСАН
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Эрүүл мэндийн бодлого

1.1.1. 3.Үндэсний хэмжээний хөтөлбөр боловсрогдоогүй байгаа ч аймгийн хэмжээнд “□□үү□ □□□□□□ □□□□□□□□” □□□□□□□□□□а болзлыг боловсруулан хэрэгжүүлж байгаа байгууллага одоогоор 31 байгууллага болж,эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох саналаа ирүүлсэн байгууллага 52 байна.

/Хэрэгжилт-30%/

1.1.6. Сум, өрх, нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны стандартыг шинэчлэхэд оруулах саналыг авч нэгтгэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.

/Хэрэгжилт-30%/

1.1.7. 2009 онд аймгийн нэгдсэн эмнэлэгт явуулын амбулаторийн үйлчилгээний тоног төхөөрөмжөөр тоноглогдсон 2 автомашинтай болж, сумдын иргэдэд үйлчилж байна.

/Хэрэгжилт-30%/

1.1.11. Алсын зайн оношлогооны тоног төхөөрөмжийг нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тасагт байрлуулан, клиникийн III эмнэлэгийн оношлогооны сүлжээнд холбож, оношлогоо эмчилгээнд ашиглахад бэлэн болсон.

/Хэрэгжилт-30%/

1.1.13. 50 ортой төрөх эмэгтэйчүүдийн эмнэлгийн барилга баригдаж байна. Барилгын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна. Хүүхдийн тасагт “Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулья төслийн хүрээнд “Дэлхийн зөн” ОНХХ-ийн газраас төрөх байрны засварт 2,999 сая төгрөг, хүүхдийн болон төрөх тасагт 15,720 сая төгрөг, шүдний зөөврийн боорий машин 1,723 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмжийг нийлүүлээд байна.

/Хэрэгжилт-30%/

1.1.19. 1. УИХ-ын тогтоолоор батлагдсан “Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого”-ыг аймаг орон нутагт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

/Хэрэгжилт-30%/

2.□□□□□□ □□□□□, □□□□□□□□ □□□□□□□□□□□□ □□ □□□□□□□□□□ □□□□□□□□□□ □□□□□□□□х зорилгоор 18 байгууллага, 300 алба хаагчдад нийтийн биеийн тамир, хөдөлгөөн, зохистой хооллолтын талаарх сургалтыг Нийгмийн хөгжлийн хэлтэс, Биеийн тамир спортын газар, Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд явуулж сургалттай холбоотой гарын авлага, СД –ээр хангаж хэрэгжилтийн явцын тайланг авч дүгнэхэд хэрэгжилт 90 хувьтай гарсан байна.

/Хэрэгжилт-30%/

3.2009 онд аймгийн БТСГ-ын барилгыг 100,0 сая төгрөгөөр засаж, тохижуулсан.

/Хэрэгжилт-30%/

1.1.20. Аймгийн Засаг даргын 2009 оны 167 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Глобаль сангийн дэмжлэгтэйгээр 2008-2013 он хүртэл “Эхээс урагт тэмбүү өвчин халдварлах эрсдэлээс сэргийлэх нэг цэгийн үйлчилгээ” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Улирал бүр үйлчилгээний болон шинжилгээнд хамруулсан тайланг авч нэгтгэн дүгнэж, Монголын ДОХ – той тэмцэх нийгэмлэгт мэдээлдэг тогтолцоо бий болсон. БЗХӨ/ХДХВ хөтөлбөрийн хүрээнд сумын эмнэлгийн 20 сувилалчийг түргэвчилсэн оношлуураар богино хугацаанд БЗДХ/ХДХВ –ын халдварыг илрүүлэх шинжилгээг гардан хийх сургалт зохион байгуулж, илрүүлэх, эргэн мэдээлэх харилцаа холбоог бий болгосон.

/Хэрэгжилт-30%/

Боловсролын бодлого

1.2.2. 1.Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ хүрч чадахгүй байгаа малчдын хүүхдэд хүртээмжтэй, үр ашигтай боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх үүднээс үндсэн бүлгийн сургалтаас гадна багт түшиглэсэн нүүдлийн гэр цэцэрлэгийг 19 цэцэрлэг 49 багт зохион байгуулж, 10 сумд явуулын багшийн сургалтыг явуулан 2798 хүүхдийг хамрууллаа.

/Хэрэгжилт-30%/

2.2009 онд Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 294-р тогтоолоор батлагдсан Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлын дундаж нормативыг үндэслэн хүүхдийн цэцэрлэгийн үндсэн бүлгийн 2505 хүүхдэд 1.185154.0 мянган төгрөг, хувилбарт сургалтын 900 хүүхдэд 142.333.7 мянган төгрөгийн зардлыг олгон үйл ажиллагаа явуулж байна.

/Хэрэгжилт-30%/

4. Богд сумын хүүхдийн цэцэрлэгт Хөдөөгийн эмэгтэйчүүдийн хөгжлийн сан, Италийн “Хүмүүнлэгийн төлөө” байгууллагаас гал тогооны зарим тоног төхөөрөмжийг, БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар Баянцагаан сумын хүүхдийн цэцэрлэгт, Баянхонгор аймгийн Тогтвортой амьжиргаа хөтөлбөрөөс Гурванбулаг, Баянхонгор сумын 6-р цэцэрлэгүүдэд гал тогооны иж бүрэн тоног төхөөрөмж нийлүүлж, мөн Жаргалант, Шинэжинст сумдын цэцэрлэгүүдийн зөөлөн эдлэлийг шинэчлэн, Баянхонгор сумын 2,4,6-р цэцэрлэгүүд ариун цэврийн өрөөний тохижилтыг загвар болохуйц түвшинд тохижуулж эрүүл ахуйн шаардлагыг хангасан орчинг бүрдүүллээ.

/Хэрэгжилт-30%/

5. Баянцагаан сумд 100 хүүхдийн хүчин чадалтай хүүхдийн цэцэрлэгийн барилга шинээр ашиглалтад орж, Богд сумын хүүхдийн цэцэрлэгийн их засварыг боловсролын хөрөнгө оруулалтаас, Баянхонгор аймгийн Тогтвортой амьжиргаа төслөөс 5 цэцэрлэгийн дээвэр, цонхыг бүрэн хэмжээнд, Баянхонгор сумын 3-р цэцэрлэгийн цэвэр, бохир усны холболтыг шинэчлэсний үр дүнд цэцэрлэгийн үндсэн бүлэг 6-аар нэмэгдсэн байна. Заг, Шинэжинст сумын хүүхдийн цэцэрлэг, Баянбулаг сумын сургуулийн спорт заалыг шинээр барих зураг төсөв хийлгэж Баянбулаг сумын цэцэрлэгийн дээвэр, халаалтын засварын зураг төсөв хийгдэж Жей-Си-Эс ОУБ-аас 14,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засварласан. Баянхонгор сумын 6-р цэцэрлэгийг цэвэр бохир усны шугамд холбох зураг төсөв, 3-р цэцэрлэгийн цэвэр бохир усны холболтын төсөв, 1-р яслийн барилгын засварын зураг төсөв, БСГ-ын барилгын зураг зэргийг шинээр хийлгэсэн. Боловсрол соёлын салбарын барилга байгууламж, объектуудын судалгааг гаргаж засварт орох ээлж дарааллыг тогтоосон.

/Хэрэгжилт -30хувь/

- 1.2.3. 2009-2010 оны хичээлийн жилд бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 98.0 хувь, суурь боловсролын хамран сургалтын бохир жин 106, цэвэр жин 99 хувь, сургууль завсардалт 0.15 хувьтай байна. Хамран сургалт 99 хувьтай байна.

/Хэрэгжилт-30%/

- 1.2.4. 5. Цэцэрлэгийн эрхлэгч, цэцэрлэгийн туслах багш, нийгмийн ажилтан, англи хэл, бага ангийн багш нарын 7 удаагийн сургалтыг гадны төсөл хөтөлбөрийн санхүүжүүлэлтээр, 10 сургалтыг багш нарын мэргэжил дээшлүүлэх зардлаар тус тус зохион байгууллаа. “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачлагын түншлэл” буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн санхүүжилтээр бага ангийн багш нарын Мэдээлэл Харилцааны Технологийн ахисан түвшний сургалтыг бүс, аймаг, сургуулийн хэмжээнд 3 үе шаттайгаар зохион байгуулж энэхүү сургалтанд нийт 324 бага ангийн багш, сургуулиудын мэдээлэл зүйн багш, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан англи хэлний багш нар, цэцэрлэгийн эрхлэгч, туслах багш нарын 3 удаагийн төвлөрсөн сургалтанд 89 багш хамрагдсан байна. 2009-2010 оны хичээлийн жилийн багш нарын бага хурлаар “Багшийн ажлын чанарыг дүгнэн тооцох түр журам”, багш нарын багшийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, багш ёс зүйн зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх, ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг судлан тогтоох ажиллагааг орон нутагт зохицуулан зохион байгуулах зорилготой “Багшийн ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг зэргийг хэлэлцэж баталж мөрдөн ажиллаж байна.

/Хэрэгжилт-30%/

6. Боловсролын удирдах ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан, албан бус боловсролын арга зүйчид болон мэргэжлийн багшийн 24 удаагийн сургалт, семинар зохион байгуулагдаж давхардсан тоогоор 880 гаруй багш хамрагдсан. Төвлөрсөн сургалтад англи хэл, цэцэрлэгийн эрхлэгч, туслах багш зэрэг нийт 89, МУБИС дээр төрөлжсөн хичээлүүдийн сургалтад 50 гаруй багш, бүсийн төв сургуулиудад 200 гаруй багш мэргэжил боловсролоо дээшлүүлсэн байна. Багш нар өөрсдийн мэргэжлээрээ судалгаа шинжилгээний ажил хийснээр боловсрол судлалын магистрын зэрэг хамгаалсан багш өмнөх оныхоос 0,1 хувиар, бакалаврын зэрэгтэй багш 5 хувиар тус тус өссөн байна.

/Хэрэгжилт-30%/

- 1.2.5. 1. Өмнөх онуудад 18-35 насны залуучуудын бичиг үсгийн боловсролын статистик мэдээ зөрөөтэй байсныг дахин шинэчилж бичиг үсэг үл мэдэгчдийн судалгааг сум, багаар 2 удаа нарийвчлан гаргаж нэгтгэн үзэхэд одоогийн байдлаар 875 залуучууд байгаагаас сүүлийн хагас жилийн байдлаар 525 иргэн бичиг үсэг тайлагдах сургалтад хамрагдсан нь нь бичиг үсэг тайлагдалтыг 60 хувьд хүргэх зорилтоо хангах түвшинд хүрсэн байна.

/Хэрэгжилт- 30 хувь/

2. Сургууль түшиглэсэн гэгээрлийн төвүүд дээр нөхөн боловсрол олгох, боловсролын ерөнхий түвшний сургалтад 1279, амьдрах ухааны сургалтад 902, мэдээлэл харилцааны сургалтад 153, гадаад хэлний сургалтад 500, бусад сургалтад 329 хүн, нийт 3000 гаран иргэд хамрагдсан байна. 24 гэгээрлийн төвөөр дамжуулан дүйцсэн хөтөлбөрөөр бага боловсролд 343, суурь боловсролд 333 суралцагч суралцсанаас 70 нь суурь боловсрол эзэмшиж, бүрэн дунд боловсролд 87 суралцагч суралцсанаас 26 нь төгссөн байна. Боловсрол нөхөн олгох сургалт нь бага, суурь, бүрэн дунд боловсролын стандарт, холимог бүлгийн арга зүйд тулгуурлан явагдаж байна. АББ-ын арга зүйчдийн сургалт семинарыг 2 удаа, ур чадварын уралдааныг зохион байгуулснаар туршлага

солилцон мэдлэг чадвараа дээшлүүлээ. Нийт арга зүйчдийн 70 хувь нь 5-аас дээш жил тогтвортой ажиллаж байна.

/Хэрэгжилт- 30 хувь/

- 1.2.6. 3.Төрөөс 12 жилийн сургалтаар хичээллэж байгаа 1-2-р ангийн сурагчдын сурах бичгийг 100 хувь, 11 жилийн сургалтаар хичээллэж байгаа 2-р анги, 3-5-р ангийн сурагчдын сурах бичгийг 40% тус тус хангаж БСШУЯ-аас гаргасан хуваарийн дагуу хүргүүлсэн. Энэ жил сурах бичгийг хэвлэн түгээх ажлыг хэвлэлийн Сод пресс, Соёмбо принтинг, Адмон, Мөнхийн үсэг, Улаанбаатар хэвлэл компаниуд хариуцан хэвлэж сургуулиудад хугацаанд нь хүргэсэн

/Хэрэгжилт-30%/

- 1.2.7. 1.Хөдөөгийн 21 сургууль сурагчдын дотуур байрны сурагчдыг хооллоход зоиулагдсан гал тогооны газартай. Аймгийн төвийн 4 сургууль багш, сурагчдад зориулагдсан цайны газартай. Сурагчдын үдийн цай хөтөлбөрийг дээрх цайны газрууддаа бэлтгэн өгч байна. Номундалай цогцолбор сургуулийн гал тогоонд “ Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилын түншлэл” буцалтгүй тусламжийн хөтөлбөрөөс гал тогооны иж бүрэн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. Эрдэнэмандал сургууль нь өөрсдийн хүчээр гал тогооны газраа засварлан тохижуулсан. 2010 онд Номгон ахлах сургуульд “ Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл” буцалтгүй тусламжийн хөтөлбөрөөс 23,000,0 ам долларын санхүүжилтээр “ загвар гал тогооны газар” ыг барьж өгөхөөр төлөвлөгдсөн. Дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулах талаар анхаарч ажиллан Бөмбөгөр, Баянговь, Жаргалант, Богд сумдын дотуур байрны их засварыг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хийсэн. Мөн дотуур байранд бага насны хүүхдийг хамруулах, тэдэнтэй хэрхэн ажиллах талаар дотуур байрны багшийг “Бага насны хүүхэдтэй ажиллах арга зүй” сэдэвт сургалтанд хамруулсан. Дотуур байр бүрийг хүүхэд хөгжүүлэх, чөлөөт цагийг нь зөв боловсон өнгөрүүлэх танхимтай болгосон.

/Хэрэгжилт-30%/

2.Монгол Улсын засгийн газрын “ Үдийн цай “ хөтөлбөрт Баянхонгор аймгийн ЕБ-ын 29 сургуулийн 1-5 дугаар ангийн 9647 хүүхэд хамрагдаж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд юуны өмнө Засгийн газрын “ Үдийн цай “хөтөлбөр, БСШУ-ны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 379/341 дүгээр тушаалаар батлагдсан ЕБС-д “ Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөх журмыг баримтлан хэрэгжүүлж байна. 2009 оны сүүлийн хагас жилд аймгийн засаг даргын захирамжийн дагуу аймгийн төвийн сургуулиудад “ үдийн цай” хөтөлбөрийг орон нутгийн хүнсний үйлдвэрлэл явуулдаг аж ахуйн нэгжүүдийн дунд тендер зарлан шалгаруулан гүйцэтгүүлж, туршин хэрэгжүүллээ.Мэргэжлийн байгууллагуудын шалгалтаар аж ахуйн нэгжүүдийн үйлчилгээний чанар муу байгаа нь тогтоогдсон учир дээрх шийдвэрийг аймгийн засаг дарга хүчингүй болгож, БСШУ-ны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 379/341 дүгээр тушаалын дагуу сургуулийн гал тогоог түшиглэн, бүтээгдэхүүнийг орон нутгийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйгаас нийлүүлэн, сургуулийн захиргаа хэрэгжүүлж , ажиллах шийдвэрийг гарган, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

/Хэрэгжилт-30%/

- 1.2.9. 1.Аймгийн төвд 4-р 11 жилийн сургууль шинээр ашиглалтад орсноор гурван ээлжээр хичээллэж байсан анги бүлгийн тоо 12-оор цөөрсөн ба Номгон, Номундалай сургуулиуд гурван ээлжгүй боллоо.

/Хэрэгжилт-30%/

- 1.2.10. 1. Аймгийн төвд 2011 онд усан бассейн баригдахаар төсөвлөгдсөн.

/Хэрэгжилт-10%/

- 1.2.12. 2. Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сургалтын бүтцийг олон хувилбартай уян хатан болгож 1, 2, 2,5 жилийн ангиудад мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор шинээр **587** суралцагч элссэний **287** нь суурь боловсрол эзэмшигч байгаа нь нийт шинээр элссэн суралцагчдын **49** хувийг эзлэж байна. Энэ нь өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад **/646 элсэгчээс 628 буюу 97 хувь нь** суурь боловсрол эзэмшигчид байсан/ суурь боловсрол эзэмшигчдийн элсэлтийг 48 хувиар бууруулсан байна.

/Хэрэгжилт- 30%/

- 1.2.20. 1. Баянхонгор аймгийн МСҮТөвд .

/Хэрэгжилт-30%/

- 1.2.25. 1.2009 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянбулаг сумын соёлын төвийн барилгын дуусгалыг 24.5 сая төгрөгөөр, Баян-өндөр сумын соёлын төвийн барилгын дуусгалд 30.1 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж барилгын ажил 80%-тай явагдаж байгаа ба Баянцагаан, Бууцагаан сумын соёлын төвийн барилгын зураг төсвийг хийж БСШУЯ-нд хүргүүллээ.

Өрхийн амжиргаа төслөөр Баянлиг сумын соёлын төв 10 сая төгрөгийн тохижилт, Баацагаан сумын соёлын төв 10 сая төгрөгийн халаалт, засвар, Галуут сумын соёлын төв 5 сая төгрөгийн халаалт, цонх, Бууцагаан сумын соёлын төвийн засвар тохижилт 3.3 сая, ДЗОУБ-ийн санхүүжилтээр 8.0 сая

төгрөгийн засвар тохижилт, Гурванбулаг сумын номын сангийн засвар, тохижилтод 11.5 сая төгрөгийн ажлууд хийгдэж нийт 2009 онд улсын төсөв, тогтвортой амьжиргаа, ДЗОУБ-ын хөрөнгө оруулалтаар нийт 102.4 сая төгрөгийн засвар, халаалт, тохижилтын ажлууд тус тус хийгдлээ.

/Хэрэгжилт-30%/

3.Аймгийн Нийтийн номын сангийн 8 компьютерийг дотоод сүлжээ, интернетэд холбон, LIB4U цогц программыг суулгаж цахим номын сангийн үйлчилгээг эхэлж, 600 номыг электрон каталогт оруулж, ЕБС-ийн сургууль, цэцэрлэгийн 1018 уншигчдад 138 удаа электрон цахим үйлчилгээ үзүүлж, 42 уншигчдад И-мейл хаяг нээн ажиллаж байна. Номын сан шинээр 525 номоор фондоо баяжуулж, шинээр баригдсан Номын өргөөнд үйл ажиллагаагаа явуулж үйлчлүүлэгчдийн тав тухтай орчинг бүрдүүллээ. Орон нутгийн бүх номын санг компьютертэй болгож, номын фондыг баяжуулахад 19.0 сая төгрөг зарцуулж, үйлчилгээний хүрээ хүртээмж нэмэгдлээ. Сум бүр алслагдсан малчдад явуулын номын сангаар үйлчилэх график гаргаж, ахуй, соёл, эмнэлгийн үйлчилгээтэй хамт хүргэж байна.

/Хэрэгжилт-30%/

- 1.2.28. 3.Үндэсний түүх, нүүдлийн соёлоо судлан сурталчлах, монгол бичгээ өвлүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж “Монгол бичиг”, “Морин хуур”, уртын дуу, монгол хөөмий, монгол бий, биелгээ, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Ламын гэгээн Лувсанданзанжанцантай холбоотой үзмэрүүдээр ил захидал хэвлүүлж ард иргэдэд сурталчилж байгаагийн зэрэгцээ, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2009 оны 136 дугаар тогтоолоор Галуут сумын нутаг дахь “Хонгор хайрхан” уулыг “Аймгийн тахилгат” уул болгож, музейн лого болох МЭӨ 3-4- р зууны холбогдолтой хос хүрэл морины хөшөөг 9.0 сая төгрөгөөр барилсан. Аймгийн Музейн бүртгэл мэдээллийн санд байгаа ТСД-газруудын видео цомог хийж эхлээд одоогоор 5 сумын 12 дурсгалт газруудын зургыг оруулаад байна. Сумдын соёлын төвүүд нутаг дэвсгэртээ байгаа ТСҮХДГ-ын фото альбомыг цахим хэлбэрээр хийж ЕБС-ийн сурагчдийн хичээлд хэрэглэж ТСД -газруудаа сурталчилж байна. “Морин хуур-уртын дуу” үндэсний хөтөлбөрийн хүрээнд морин хуурч, уртын дууч, морин хуур урлаачдын нэгдсэн судалгаатай болж тэдний арга барил, дэг сургуулийг өвлүүлэн, алдаршуулах, сургалт сурталчилгаа, төрөл бүрийн уралдаан наадамудыг жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж жилдээ 2.4 сая төгрөгийг “Морин хуур, уртын дуу” хөтөлбөрийн хэрэгжилтэнд зарцуулан хөтөлбөр 93.3 хувьтай хэрэгжиж байна. Монгол хөөмий, Монгол уламжлалт бий, биелгээ хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2009 оны 91-р захирамжаар батлан уг хөтөлбөрүүдийг Утга соёлын өвийн үндэсний төвтэй хамтран үүсэл хөгжил, тархалтыг судлан холбогдох байгууллага, ажилтнуудын дунд сургалт зохион байгуулж, сургалтын CD- авч сургагч багш бэлтгэж байна. Хөөмий сонирхогч залуучуудын дунд хөөмийн сургалтыг ХДТ, Соёлын төвүүдийг түшиглэн бүсчлэн зохион байгуулж одоогоор 20 гаруй хөөмий сонирхогч залуучууд суралцаж, амжилттай суралцсан Баян-өндөр сумын ардын авъяастан Мөнхбаярыг СУИС-ийн хөөмийн ангид суралцуулахаар сургалтын албатай тохиролцоод байна.

/Хэрэгжилт- 30 %/

Нийгмийн хамгааллын бодлого

- 1.3.1. 1.Хөдөлмөрийн багтаамж өндөртэй нийтийг хамарсан 29 ажилд 833 ажилгүй бүртгэлтэй иргэдийг хамруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 70.4 сая төгрөг зарцуулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд 1999 хүнийг ажлын байранд зуучилснаас 1224 хүн байнгын зохистой ажлын байранд, 775 хүн түр ажлын байраар хангагдсан байна.

/Хэрэгжилт-30%/

- 1.3.6. 2.“Нэг өрх-нэгээс доошгүй ажлын байр “ хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

/Хөтөлбөр боловсрогдож гараагүй байгаа/

/Хэрэгжилт-0%/

- 1.3.7. 1.Эрэлтэд тулгуурласан “Эрхийн бичиг”-ийн сургалтыг орон нутагт өргөжүүлнэ. /Хэрэгжилт-0%/

- 1.3.15. 1. Аймгийн хэмжээнд 2 Мэргэжил Сургалтын төв үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 2009-2010 оны хичээлийн жилд БСШУЯ-ы харъяа Мэргэжил Сургалтын Төв 1773 суралцагч, Өлзийт Мэргэжил Сургалтын Төв 540 суралцагчтайгаар сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Өнгөрсөн жилийн суралцагчдын тоотой харьцуулбал БСШУЯ-ы харъяа Мэргэжил Сургалт -Үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын тоо 15%, Өлзийт Мэргэжил Сургалт-Үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын тоо 60 хувиар өссөн байна.

/Хэрэгжилт-30%/

- 1.4.1. 1.Нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх, тэднийг чадавхижуулах зорилгоор 2009 оны 6-р сард “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачлагын түншлэл” хөтөлбөрийн хүрээнд “Зургаан настай суралцагч, нийгмийн ажлын үйлчилгээ” сэдвийн дор нийгмийн ажилтнуудын 3 өдрийн сургалтыг БСШУЯ , Олон Улсын Каталитик сантай хамтран зохион байгуулсан. Мөн 2009 оны 9-р сард Хүүхэд хамгааллын асуудал ба хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нь” сэдэвтэй 3 өдрийн сургалтыг БСШУЯ, НХХЯ, Нийгмийн ажилтан, багш, суралцагчдын холбоо хамтран зохион

байгууллаа. Хүүхдэд ээлтэй сургууль”, Модуль” 5, 6, 7-р сургалтуудыг явуулж нийгмийн ажилтнуудыг хамрууллаа.

/Хэрэгжилт-30%/

- 1.4.6. 1.Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс нь ажлын байрны зохион байгуулалтыг нэг цонхны 2.Сум бүр ядуурлаас гаргах өрхүүдийн мэдээллийг агуулсан өрхийн хөгжлийн дэвтэр нээн сургалтад хамруулсан, дэмжлэг үзүүлсэн, зээлд хамруулсан талаарх тэмдэглэлийг тухай бүр нь хийж байна. Сонгогдсон өрхүүдээс 30 өрхийг жижиг зээл олгох үйлчилгээнд, 20 хүнийг гар утасны, 40 хүнийг гутал засварын мэргэжил олгох сургалтад, аж ахуй эрхлэх сургалтад 85 хүнийг, нийтийг хамарсан ажилд 188 хүнийг, ногоон ажлын байр хөтөлбөрт 165 хүнийг, 1 өрх 1 ажлын байр хөтөлбөрт 8 өрх, жижиг зээлийн хөнгөлөлтөд 8 өрх, олон нийтийн оролцоонд тушиглэсэн арга хэмжээнд 210 хүнийг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 235 хүнийг тус тус хамруулан өрхийн орлогыг нэмэгдүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 59.3 сая төгрөг зарцуулсан.

/Хэрэгжилт-30%/

үйлчилгээнд шилжүүлж иргэдэд халамжийн мөнгөн тэтгэлгийг “ХААН”, “ Шуудан банк”-уудаар түргэн шуурхай, чирэгдэлгүй дамжуулан олгож байна.

/Хэрэгжилт-30%/

- 1.4.11. 1.Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” ийн хүрээнд 470 өрхийн хөгжлийн төлөвлөгөө хийж 288 өрхийг ядуурлаас гаргаж 321 хүнийг чадавхижуулах сургалтад хамруулж, гэр бүлийн орлого нэмэгдүүлэх сэтгэлгээ суулгасан. 2010 онд сумдын амьжиргааг дэмжих зөвлөлийн үйл ажиллагаа чанаржуулж, гэр бүлийг хөгжүүлэхэд ажил үйлчилгээг нь чиглүүлэх бодлого баримталж байна.үндэслэн бүс нутгийн болон эдийн засаг, дэд бүтцийн хөгжилтэй уялдсан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

/Хэрэгжилт-30%/

- 1.4.15. 2. Иргэд, хамт олны дунд 4 удаагийн тэмцээн, уралдаан зохион байгуулсан ба нийт 10136 хүн оролцсон нь урьд оноос иргэдийн оролцоо 15.3 хувиар нэмэгдсэн байна. Тухайлбал “ Идэвхтэй хөдөлгөөн эрүүл аж төрөх ёс”, ахмадуудын дунд “Хөдөлгөөн эрүүл байх үндэс”, “Эрүүл мэндийг дэмжигч” байгууллагын тоо урьд оноос 4-р нэмэгдэж 31 болоод байна. Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар нь олон нийтэд хийсэн ажлаа сурталчлах, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор өөрийн тогтмол хэвлэлтэй болж, 12 удаагийн сонин гаргасан.

/Хэрэгжилт-30%/

3.“Хонгор телевиз, “All design” хэвлэлийн байгууллагатай эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны гэрээ байгуулж, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох талаар 48 удаагийн нэвтрүүлэг бэлтгэн явуулж, олон нийтэд түгээсэн. Мөн хөдөө орон нутагт олон нийтэд эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор сумдын нийгмийн эрүүл мэндийн ажилтан болон сайн дурын идэвхтнүүдэд сургалт явуулан ажлын төлөвлөгөө өгч үр дүнг тооцон ажилласан. Албан байгууллага, иргэд олон нийтэд 48 удаагийн сургалт, семинар, ярилцлага, лекц, танхимын болон зайны сургалтын хэлбэрээр 40.0 орчим мянган хүн амд эрүүл мэндийн боловсрол олгож, зан үйлийг өөрчлөхөд нөлөөлж, санал асуулга авч үнэлэлт дүгнэлт өгч, үр дүнг тооцсон.

/Хэрэгжилт-30%/

Макро эдийн засаг, санхүүгийн бодлого

- 2.1.2. 1.Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдлийг аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2010, 2011, 2012 оны төсвийн төлөвлөлтийг боловсруулан Сангийн яаманд шалгуулан тусгаж цаашдаа нэмэх өөрчлөлтийг жил бүрийн үндсэн чиглэлд оруулан батлуулан ажиллаж байна.

/Хэрэгжилт-30%/

2.Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах ажлын байрыг нэмэгдүүлэх жилийн хүрээнд 2010 оны 03 сарын 13-ны өдөр аймгийн ЗДТГ, Мерси Корын төлөөлөгчдийн газартай хамтран “Гурван талт түншлэлийг хөгжүүлэх замаар орон нутаг дахь ажилгүйдлийг бууруулах хэлэлцүүлгийг зохион байгуулан тодорхой санал санаачлагыг дэмжиж ажиллах уриаг нь гарган түүний мөрөөр ажил зохион байгуулж эхлээд байна.

/Хэрэгжилт-30%/

- 2.1.10. 1.Хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгийг аймгийн эдийн засгийн гол чиглэл болох Уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлалтай уялдуулах талаар саналаа УИХ, Засгийн газарт хүргүүлээд байна.

/Хэрэгжилт-30%/

Үйлдвэржүүлэх бодлого

- 2.2.5. 1.Ноос угаах үйлдвэр байгуулах чиглэлээр төсөл боловсруулж ХХААХҮЯ-нд хүргүүлж, тоног төхөөрөмжийг лизингээр худалдан авахаар төлөвлөн судалгаа хийгдэж байна.

/Хэрэгжилт-30%/

2.2009 онд аймгийн төвд “ Баруун шанд” ХХКомпани сүү боловсруулах үйлдвэр, Баянлиг сумд “Их халбаганат” ХХКомпани ингэний ундаа савлах цех байгуулан орон нутгийн иргэдэд, мөн сургуулийн сурагчдын “Үдийн цай” хөтөлбөрт нийлүүлж байна.

/Хэрэгжилт-70%/

3. Эсгий , эсгий эдлэл, ноосон эдлэлийн жижиг үйлдвэрлэлийг энэ чиглэлийн хүрээлэн, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.

/Хэрэгжилт-30%/

4.Аймгийн хэмжээнд ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд аймагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудад орон нутгийн иргэдийг ажилд авах санал тавьж одоогийн байдлаар 71 иргэн ажлын байраар хангагдаад байна. Ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт боловсруулах үйлдвэрийн мэргэжилтэй ажилчдын нөөц судалгааг тогтоон гаргах, ажилтан бэлтгэх хөтөлбөртэй ажиллах чиглэл гаргасан.

/Хэрэгжилт-30%/

2.2.6. 1. Аймагт тэргүүн ээлжинд уул уурхайн үйлдвэрийг дэмжин хөгжүүлж үүнийг түшиглэн барилгын материалын төрөл бүрийн жижиг үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжин ажиллаж байна.

/Хэрэгжилт-70%/

2.2.7. 4. Аймагт жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх шинэчилсэн дэд хөтөлбөрийг ИТХ-аар батлуулан үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийг нарийвчлан тогтоож мөрдөн ажиллаж байна.

/Хэрэгжилт-30%/

2.3.1. 2. 2009 онд Баянлиг суманд 5.6 сая төгрөгийн өртөгтэй сүү боловсруулан савлах цех, Баянхонгор аймгийн төвд 70,0 сая төгрөгийн өртөгтэй сүү боловсруулан савлах дунд үйлдвэр ашиглалтан оруулж, “Үйлдвэржилтийн жил” болгон зарласантай холбогдуулж жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төслийн хөнгөлөлттэй зээлийг 50 аж ахуй нэгж, иргэнд нийт 743 сая төгрөгийн зээл олгосон.

/Хэрэгжилт-50%/

3. Сүү үйлдвэрлэгчид сүүг нэгдсэн байдлаар цуглуулах, хөргөх, боловсруулах бэлтгэлийн тогтолцоог одоогоор бүрдүүлж чадаагүй байна.

/Хэрэгжилт-10%/

5.Аймгийн 2009 оны тариалангийн үйлдвэрлэл 2007 оныхоос 115 өрх, 16 аж ахуйн нэгж, 75,2 га талбай, 374,9 тонн ургацаар, 2008 оныхоос 45,6 га талбай, 395 тонн ургацаар тус тус нэмэгдээд байна.

/Хэрэгжилт-50%/

6.Аймгийн хэмжээнд сүү цагаан идээ, талх нарийн боов, архи, хэрчсэн гурилын үйлдвэрлэл эрхэлж буй нийт 8 хүнсний үйлдвэр үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байна. Эдгээр хүнсний үйлдвэрүүдээр 9 дүгээр сард тухайн үйлдвэрийн түүхий эд бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж ашиглалтын судалгаа, явуулж, үр дүнг нь тооцсон. 11 дүгээр сард аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг бүх дэлгүүр, нийтийн хоолны газруудаас тусгай зөвшөөрөлтэй, хэдэн нэр төрлийн бараа бүтээгдэхүүн зарж борлуулдаг зэрэг судалгааг аван үр дүнг тооцоход нярай хүүхдийн хоол, тэжээлийн болон түүнд чиглэсэн үйлчилгээ дутмаг байлаа.

/Хэрэгжилт-10%/

2.3.5. 1. Баянхонгор аймаг 2009 онд 20 аж ахуйн нэгж, байгууллага, 1134 өрх 482,4 га талбайд тариалалт хийсний дотор 291,1 га-д төмс, 113,1 га-д хүнсний ногоо, 7605 га-д тэжээлийн ургамал, 4,2 га-д арвай тариалж, 2304 тонн төмс, 960 тонн хүнсний ногоо, 7,5 тонн арвай, 146,3 тонн тэжээлийн ургамал хураан авч, аймгийн хүн амын жилийн хэрэгцээт төмсний 63,9 хувь, хүнсний ногооны 26,6 хувийг өөрийн ургацаар хангаад байна.

/Хэрэгжилт-30%/

2. Сумдын Засаг дарга нарт төмсний үрийн сан байгуулах талаар удирдамж үүрэг даалгавар өгөгдсөн. Төлөвлөсөн хөрөнгө хүрэлцэхгүйгээс сум бүр 4 тн үрийн нөөц бүрдүүлэх боломжгүй болсон ч үрийн төмсний санг бүрдүүлэх чиглэлээр сум бүрт эхлэл тавигдав. НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын “Үнийн эрсдэлд өртөж болзошгүй тариалан эрхлэгчдийг дэмжих төсөлд 12 сумын 110 өрхийг хамруулж, төмс, хүнсний ногооны үр олгов.

/Хэрэгжилт-30%/

2.3.6. 1. Нийт 430.9 мянган малд үзлэг, 93.3 мянган малд ангилалт хийж, ямааны ноолуурын гарц, микроны хэмжээ, хаврын амьдын жингийн хэмжээ, биеийн үндсэн хэмжээний дунджийг бүс нутаг малын үүлдэр бүрээр тодорхойлсон. Сумдад үржлийн зориулалтаар ашиглаж байгаа богийн 14237 хээлтүүлэгч малд үзлэг ангилалт хийж, хянан баталгаажуулалтанд хамруулж, үржлийн бүртгэлийн баяжилтийг хийлгэн, ашиг шимийн судалгааг авсан. Малын үзлэг ангилалтын ажилд улсын төсвөөс 8 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж үзлэг ангилалтаар тоологдсон хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироогоор аймгийн хэмжээгээр бодын тохироо нормын хэмжээнд, богийн тохироо нормын хэмжээнээс хэтэрсэн дүнтэй байна. Нэг хуцанд 64 хээлтэгч, нэг ухнанд 82 хээлтэгч тус тус ноогдож байна. Иймд сумуудад өсвөр хээлтүүлэгч нөхөн тавихад шаардлагатай үржлийн цөм сүрэг бүрдүүлэх талаар тооцоо судалгаа гарган зөвлөмж өгөв.

- /Хэрэгжилт-30%/
- 2.Баянлиг сумын тэмээн сүрэгт бруцеллэзийн шинжилгээг 2010 онд хийнэ. /Хэрэгжилт-10%/
- 3.Цөм сүргийн үржлийн төв аттестачлалд орж , 1600 гаруй малтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. /Хэрэгжилт-30%/
- 2.3.7. 1. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг манай аймагт Өлзийт сумыг сонгон бодлого чиглэлээ төвлөрүүлэн ажиллаж байна. /Хэрэгжилт-30%/
- 2.Өлзийт суманд мах сүүний чиглэлийн үхэр үржүүлж, эрчимжсэн аж ахуй байгуулж гахай, тахианы аж ахуй эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, өрхөд аймгийн ХБХ-ийн мэргэжилтэн, ХХААЖДҮГ-ын мэргэжилтнүүд хамтран үзлэг хийхэд 1 аж ахуйн нэгж, 1 албан газар, 1 өрхөд бүгд 67 гахай, 6 өрхөд 144 тахиа тоологдов. /Хэрэгжилт-30%/
- 3.Баянхонгор аймгийн ойролцоо “Алатау” үүлдрийн 10 үнээтэй сүүний ферм байгуулагдан аймгийн төвийн сүүний үйлдвэрт сүүгээ нийлүүлж байна. /Хэрэгжилт-30%/
- 2.3.8. 1. Судлагдаж байна. /Хэрэгжилт-10%/
2. Судлагдаж байна. /Хэрэгжилт-10%/
- 2.3.10. 1. 2009 онд тэжээлийн ургамал 76,5 га-д тариалж, 187 тн ургац хураан авч хадлангийн талбай сайжруулах төсөлд Өлзийт, Бөмбөгөр, Шинэжинст сумууд хамрагдаж, тус бүр 8,0 сая нийт 24,0 сая төгрөгийн санхүүжилтээр 30 га талбайг сайжруулсан. /Хэрэгжилт-30%/
- 2.2009 онд хадлан 2393 тн, гар тэжээл 277 тн-г бэлтгэв. Сум бүрт 10,0—50,0 тоннын агуулахтай болоод байна. /Хэрэгжилт-30%/
- 2.3.11. 3.Отрын бүс нутгийн бэлчээрийн талаар асуудал боловсруулагдан аймгийн засаг даргын зөвлөлийн хурлаар оруулсан. Одоогоор Жинст сумын Хонгорын нурууг сум дундын отрын бүс нутгаар тогтоогоод байна. /Хэрэгжилт-30%/
- 2.3.12. 2.Малын гоц халдварт шүлхий, гахайн мялзан, шувууны томуу өвчнөөс сэргийлэх талаар 2007-2009 онуудад 3 удаа сургалт явуулж гарын авлага тараасан бүх сумын МЭАН-үүдийг халдвар хамгааллын хувцасаар хангаж, гарын авлагаар хангалаа. /Хэрэгжилт-30%/
- 7.МЭУАН-үүдийг бэхжүүлэхэд анхаарч эм, реактивээр хангаснаас гадна 12 аж ахуй нэгжид мотофомьп, 13 аж ахуйн нэгжид вакцины хөргөгч, 43 аж ахуйн нэгжид шөвөг ярын автомат тариур, 5 литрийн туулгалтын тариур гэх мэт хангамжийн арга хэмжээ авсан. /Хэрэгжилт-30%/
- 2.3.13. 3.2009 онд Инженерийн хийцтэй 22 шинэ худгийн тендер зарлаж 1-р багцад “Монтего”ХХК, 2-р багцад “Тунгалаг ус” ХХК, 3-р багцад “Номин хишиг”ХХК-ууд тус тус шалгарч 22 худаг гаргасан. /Хэрэгжилт-30%/
- 3.Геофизикийн хайгуул хийлгэх, худаг уст цэгийн тоог нэмэгдүүлэх талаар санал, судалгааг холбогдох газруудад байнга өгч байна. /Хэрэгжилт-30%/
- 4.Үлийн цагаан оготно устгалын арга хэмжээнд 7 сум 35000 га талбай хамрагдаж устгалын ажил 80,6%-тай хийгдсэн. /Хэрэгжилт-30%/
- 2.3.16. 1. Эрдэнэцогт сумын сарлаг үхэр, Баянлиг сумын тэмээн сүрэгт бруцеллэзийн шинжилгээг хийж эрүүлжүүлэх бодлого явуулж байна. /Хэрэгжилт-30%/
- 2.3.17. Атаршсан 40 га талбайг 2009 онд эргүүлэн ашиглав. /Хэрэгжилт-30%/
- 2.3.18. Сумдад агропарк байгуулах ажил 2008 оноос эхлэн хийгдэж, сум бүр бага оврын трактор, 120 м² талбай бүхий хальсан хүлэмжтэй, 20 сум зоорьтой болсон. /Хэрэгжилт-30%/

Дэд бүтэц, хот байгуулалтын бодлого

- 2.4.5. 2.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 01 сарын 9 ны өдрийн хуралдаанд 2009 онд өмчлүүлэх газрын хэмжээ байршлын талаар санал боловсруулан хэлэлцүүлэн батлуулж албажуулан ГХБГЗЗГазарт хүргүүлэн Засгийн газрын 2009 оны 142 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган

ажилласан бөгөөд аймгийн хэмжээнд газар өмчлүүлэх ажлыг амжилттай зохион байгуулж 5512 иргэнд 467.03 га газар өмчлүүлсэн байна.

/Хэрэгжилт-50%/

3.Баян-Овоо сумын нутаг Самбартай хөтөл, Нарийний гүүр, Бууцагаан сумын нутаг Байдраг гүүр, Баацагаан сумын нутаг Хөх эргийн гарам, Өлзийт сумын нутаг Худаг урт зэрэг газруудад улсын чанартай авто замын дагуу газар өмчлүүлэх боломжтой газруудын судалгааг нарийвчлан гаргасан бөгөөд Цагаан хөтөл орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийж одоо хөрөнгийн асуудал хөөцөлдөж байна.

/Хэрэгжилт-50%/

4.Сумдад аж ахуйн зориулалтаар болон тариалан эрчимжсэн фермерийн аж ахуйн зориулалтаар өмчлүүлэх боломжтой газрын хэмжээ, байршлыг тогтоох зорилгоор албан бичиг хүргүүлэн судалгааг нэгтгэж эхлээд байна.

/Хэрэгжилт-30%/

2.4.6.Аймгийн хэмжээнд хилийн цэсийг тодотгох ажил бүрэн хийгдсэн зарим маргаантай болон зөрөөтэй газруудын судалгааг ГХБГЗЗГазарт хүргүүлсэн байна.

/Хэрэгжилт-30%/

2.4.7.Аймгийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан “Хонгор-1000” айлын орон сууцны хороолол барих газрын байршлыг сонгож төлөвлөлтийн зураглал гарган, дэд бүтэц инженерийн шугам сүлжээний тооцоо хийгдсэн. “Орон сууц-4000” хөтөлбөрийн хүрээнд Төрийн албан хаагчдыг орон сууцны зээлд хамруулах талаар мэдээлэл сурталчилгаа хийгдэж байна. Орон сууц санхүүжилтийн корпорацийн санхүүжилтээр 20 айлын орон сууц шинээр барихаар инженерийн шугам сүлжээний ажил бүрэн хийгдсэн.

/Хэрэгжилт-30%/

2.5.2. Багийн хөгжлийн сантай болгох ажил эхлэлийн шатанд байна.

/Хэрэгжилт10%/

2.5.3. 6.Аймгийн төвд дулааны хангамжийн байдалд судалгаа хийгдэж уурын зуух болон дулааны шугам сүлжээнд 12.0 км газарт шугамын өргөтгөл, шинэтгэл хийхээр төлөвлөгдөж зураг төсөл хийх бэлтгэл ажил хийгдэж байна. Эдгээр шинэчлэлтийг хийснээр халаалтын доголдол бүрэн арилах болно.

/Хэрэгжилт-10%/

2.5.4. Заг- Гурванбулаг сумын ЦДАШ, Гурванбулаг сумын 0.4квт-ийн шугамын өргөтгөлийн ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2009 онд 84.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Бөмбөгөр -Баацагаан сумын 15 кв-ын 80км ЦДАШ,1x0.1, 1x0.16 дэд станц, Баянхонгор-Бөмбөгөр сумын 35кв-ын 83 км ЦДАШ, Дэд станц, 2x1.0, 2x0,25, Бөмбөгөр -Заг сумын 35 кв-ын 115км ЦДАШ, 35/10 кв-ын 2x0,16 мва дэд станц ажлууд хийгдсэн. Бүс нутгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтаар 2010 онд Баянбулаг Хүрээмарал сумын 10 квт-ийн ЦДАШ-ын дэд станц барихаар 1423.0 төсөвт өртөг төлөвлөгдөж Эрдэс баялаг эрчим хүчний яаман дээр зарлагдаж байгаа.

/Хэрэгжилт-70%/

2.5.6. 1.Аймагт Цементийн үйлдвэр барихаар Бридж групп гэрээ байгуулан үйлдвэрийн шавь тавиад байна.

/Хэрэгжилт-10%/

3.Аймгийн хэмжээнд 18 блокны үйлдвэр, 2 тоосгоны үйлдвэр, 1 ханын материалын үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.

/Хэрэгжилт-50%/

2.5.7. 2. 2009 оны зун аймгийн нийт нутгийн 70 хувь гантай, өвөл цас их орсонтой холбогдуулан сум, багийн Засаг дарга нарт үүрэг өгч алслагдсан нутгуудад өвөлжиж байгаа малчдад төрийн үйлчилгээг хүргэх арга хэмжээг давхардсан тоогоор 526 удаа хүргэсэн байна.

/Хэрэгжилт-30%/

2.5.9. 2009 онд Баацагаан сумын 10 ортой эмнэлгийн барилга -239.0 сая, Бөмбөгөр сумын сургуулийн дотуур байрны засвар -52.0 сая, Баянбулаг сумын соёлын төв – 224.0 сая, Богд сумын хичээлийн байрны засвар -160.0 сая, Гурванбулаг сумын дотуур байрны засвар- 160.0 сая, Эрдэнэмандал сургуулийн хичээлийн байрны засвар -31.0 сая ажлууд хийгдэж ашиглалтад орсон. 2010 онд шинээр баригдах Баянцагаан сумын Соёлын төв -600.0 сая, Бууцагаан сумын Соёлын төв -460.0 сая өртөг бүхий барилгын тендер БСШУЯ дээр зарлагдсан. Соого-Сейко Япон сургуулийн барилгын өргөтгөл -145.0 сая хөрөнгө оруулалтаар гүйцэтгэхээр “Чулуун өргөө”ХХК шалгарч гэрээ байгуулаад байна. 2009-2010 он дамжсан Баянхонгор аймгийн 50 ортой эмнэлгийн барилга -1205.6, Гурванбулаг сумын 10 ортой эмнэлгийн барилга -395.0 сая, Баянөндөр сумын Соёлын төв – 226.9 сая төгрөгийн ажил үе шаттайгаар үргэлжилж байна.

/Хэрэгжилт-70%/

Байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах зорилт

- 3.2. 1. Агаарын бохирдолыг бууруулах аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан 2009 оны ИТХ-ын Тэргүүлэгчдийн 221 дүгээр тогтоолоор батлуулан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байна. /Хэрэгжилт-50%/
- 3.3. 2. Аймгийн цэвэрлэх байгууламжын өргөтгөх, шинэчлэх ажлын зураг төсвийг 1 тэр бум 580 сая төгрөгийн өртөгтэй улсын хөрөнгө оруулалтаар хийхээр Улаанбаатар хотын “ИНЖ байгууламж” зураг төсвийн байгууллагаар зургийг хийлгэсэн. /Хэрэгжилт-30%/
- 3.4. Төлөвлөгөө боловсруулаагүй байна. /Хэрэгжилт-0%/
- 3.5. 2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 73 дугаар тогтоолоор Түйн гол, Байдрагийн голын ай савын зөвлөлийг шинэчлэн байгуулж ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ажлын эхлээд байна. /Хэрэгжилт-30%/
- 10.2010 оны 4 сараас Усны газар, сумдын ЗДТГ-тай хамтран томоохон голуудын хамгаалалтын бүсийг тогтоон тэмдэг тавих ажлыг хийхээр төлөвлөж байна. /Хэрэгжилт-10%/
- 3.6. 1. Заг, Бөмбөгөр сумдад хөв цөөрөм байгуулагдахаар төлөвлөсөн боловч санхүүгийн хямралаас болж хасагдсан. /Хэрэгжилт-10%/
2. Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Бөмбөгөр сумын Хунцатад “ЖИ-СА-ОЙ” ХХК 8 га газарт хайлаас 3500ш бургас 200, улиас 800, чацаргана 100 ширхэгийг тарьж ойн зурвас байгуулаад байна. Мөн “ОРОГ НУУР ТҮЙН ГОЛЫН ХӨДӨЛГӨӨН” ТББ Богд сумын Хориултын буланд 2 га-д 450ш чацаргана, 85ш үхрийн нүд, 30ш хайлаас, 30ш улиас, загийг үрээр бортгонд тарьж ургуулаад байна. /Хэрэгжилт-70%/
3. Хээрийн ойжуулалтыг Өлзийт сумын 3-р багийн нутаг Нарийн голд 15 га-д, Байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг Даяанчын аманд 10 га-д Бүртгэл менежментийн хонгор дээд сургуулиар хийлгэсэн болно. Швейцарийн хөгжлийн агентлагийн “Цөлжилтийг сааруулах” төсөл Баянхонгор аймагт хэрэгжиж, 4-н сургуулийг ЭКО сургууль болгохоор Баянхонгор аймгийн “Номгон” ахлах сургууль 600 ш мод, Жинст суманд 200 ш мод, Шаргалжуутад 200ш, мод тариулснаас 75 хувийн амьдралттай байна. /Хэрэгжилт- 70%/
- 3.7. Нар, салхины эрчим хүчээр ажиллах худаг уст цэг одоогоор гаргаагүй байна. /Хэрэгжилт-0%/
- 3.9. 1. Тэжээлийн ургамал 76,5 га-д тариалж, 187 тн ургац хураан авсан. /Хэрэгжилт-30%/
- 3.15. 4. Эрдэнэцогт сумын Өртөмтийн урьд салаанд шатсан 10 га талбайг ойжуулахаар 2010 оны үндсэн чиглэлд тусгаад байна. /Хэрэгжилт-10%/
7. “Хууль бусаар мод тээвэрлэхгүй, огтлохгүй, худалдан авах буюу худалдан борлуулахгүй байх” талаар санамж өгч гэрээ хийлээ. Аймгийн хэмжээнд хэрэглэгдэх хэрэглээний болон түлшний модны хэмжээг гаргаж Архангай аймаг, Баянтээх хоршоотой гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна. Хууль бус мод бэлтгэлийг зогсоохын тулд ард иргэдэд ойн санг гэрээгээр эзэмшүүлж Ойн сангийн тодорхой хэсгийг нөхөрлөл, аж ахуйн нэгжид гэрээгээр эзэмшүүлснээр ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, зохистой ашиглах зорилгоор ой хамгаалах нөхөрлөлийг Эрдэнэцогт суманд 11 нөхөрлөл байгуулж, Галуут сумд 3, Баянлиг сумд 3, Өлзийт сумд 1 нийт 18 нөхөрлөл байгуулан ажиллаж байна. /Хэрэгжилт-30%/
- 3.16. 4. Одоогоор хийгдсэн ажил байхгүй байна. /Хэрэгжилт-0%/
- 3.17. 3. Газрын нэгдмэл сангийн тайлангийн шилжилт, хөдөлгөөнийг байнга тусгаж байгаа бөгөөд байгаль орчны даац, чадавхид нийцүүлэн тухайн жилийн газар зохион байгуулалтын аймаг, сумын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. /Хэрэгжилт-30%/
3. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг тусган ажиллаж 2009 онд уул уурхайн Жамп ХХК Галуут суманд 0.5 га, Жаргалант суманд 9 га, Монголболгоргео ХХК 14.5 га, Ханшижир ХХК 8 га, Тулгажаргалант ХХК 5 га-д техникийн нөхөн сэргээлт хийснийг аймгийн комисс газар дээр хүлээн авсан. /Хэрэгжилт-30%/
- 3.18. 2. Байгаль орчин аялал жуулчлалын яамны хэрэгжүүлэгч агентлаг болох “Аялал жуулчлалын үндэсний төв” -өөс боловсруулсан “Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөрт”-т Дэлхийн элсэн манхны хойд хязгаар болох Увс аймгийн Зүүнговь сумын Бөөрөгийн элс, дэлхийн цэвдэгшлийн

өмнөд хязгаар болох Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Дарагт уул, Дэлхийн усны гурван ай савын хагалбар болох Хэнтийн нурууны төгсгөл Цогтчандмань уул зэрэг жуулчдын сонирхол татах байгалийн онцлог газруудад аялал жуулчлалын үзмэр бий болгох ажил хөтөлбөрт 2013-2015 оны хооронд хийхээр тусгагдсан байгаа, тул хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж байна. 2009 оны 12 сарын 04-06 хооронд болох “Mongolia ITF- 2009” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн” Мишээл экспо” дээр амжилттай зохион байгуулагдлаа. Үзэсгэлэнд Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хөгжлийн бодлогын хэлтэс, “Мандухай” жуулчны бааз, “Mongol khan” expedition /Говийн тэмээ/ жуулчны баазууд амжилттай оролцлоо

/Хэрэгжилт-30%/

3.Аймгийн аялал жуулчлалын холбоотой мэдээлэлүүдийг аялал жуулчлалын вэб сайтанд байрлуулж сурталчилгааны ажлыг хийгээд байна.

/Хэрэгжилт-30%/

4.Баянхонгор аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үзмэрүүд болох түүх соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газруудын талаарх мэдээ мэдээллийг одоогийн байдлаар нийт 19 сумдуудаас авч мэдээллийн дэд санд оруулаад байна. Уг мэдээлэл дотор :

- 1.Улсын хамгаалалтанд хэзээ авсан
 - 2.Байгалийн дурсгалт болон түүх соёлын дурсгалт газруудын нэрс
 - 3.Орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан
 - 4.Сумын төвөөс аль зүгт хэдэн км-т оршдог
 - 5.Аймгийн төвөөс аль зүгт хэдэн км-т оршдог
 - 6.Эзэлж буй талбайн хэмжээ
 - 7.Харъяалагдах багийн нэрс
 - 8.Холбогдох зураг /Хавсралт/
 - 9.Домог /Хавсралт/
 10. Ховор болон нэн ховор ургамал
 - 11.Улаан номонд орсон амьтан
 - 12.Сумдын томоохон дэлгүүр
 - 13.Жуулчны бааз
 - 14.Зоогийн газар гэх мэт
- мэдээлэлүүдийг нэгтгэж аялал жуулчлалын мэдээллийн санд оруулаад байна.

/Хэрэгжилт-50%/

3.Орон нутгийн жуулчны үйлчилгээний газрууд болох жуулчны бааз, зочид буудал, амралт сувилалын газруудын судалгааг гаргаж тэдгээрт стандарт мөрдүүлэх ажлыг аймгийн мэргэжлийн хяналтыг газартай хамтарч зохион байгууллаа

/Хэрэгжилт-30%/

4.Аймгийн аялал жуулчлалын цогцолбор болох Гурван бүсийн цогцолборт 2009 онд батлагдсан төсвийн хүрээнд ажил хийгдсэн.

/Хэрэгжилт-30%/

3.19. 2. Аймгийн Засаг дарга сумын Засаг даргын хооронд байгуулсан үр дүнгийн гэрээнд байгаль орчныг хамгаалах, нөөц баялагийг зүй зохистой ашиглах талаар заалтуудыг тусган үр дүнг тооцон ажиллаж байна.

/Хэрэгжилт- 30%/

3.Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар уул уурхайн салбарын нөхөн сэргээлтийн асуудлыг хэлэлцүүлж ИТХТэргүүлэгчид, ЗДТГ, МХГ, БОАЖГазар зэрэг байгууллагууд хамтран уурхай бүхий сумдаар хяналт шалгалт хийж цаашид үйл ажиллагааг хэрхэн шийдвэрлэх талаар нутгийн иргэдтэй уулзаж санал бодлыг нь сонсон цаашдын ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлтийн байдлыг аймгийн комисс газар дээр нь очиж шалган хүлээн авч байна. 2009 онд “Жамп” ХХК Галуут суманд 0.5 га, Жаргалант суманд 9 га, “Монголболгаргео” ХХК 14.5 га, Ханшижир ХХК 8 га, “Тулгажаргалант” ХХК 9 га, Баялаг богд ХХК 13 га, Одод гоулд ХХК 5.2га, Жи-Энд-Юу гоулд ХХК 22 га, Тал булаг ХХК 1.6 га, Хаан гарди ХХК 1 га, Андын тэмүүлэл ХХК 7 га-д техникийн нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгөөд байна.

/Хэрэгжилт-30%/

4.Баянхонгор аймгийн хэмжээнд иргэн Б.Содномдагвын “Зоогийн газрын барилга” –ын төсөл, “Хими цэвэрлэгээний газар” - ын төсөл, “48 айлын орон сууцны барилга” – ын төсөл, “Эмийн сангийн өргөтгөл” -ийн төсөл, иргэн Ч. Сайнбаярын худалдаа үйлчилгээний газрын барилгын төсөл, “Наран төгрөг” дэлгүүрийн барилгын төсөл, Өлзийт сумын иргэн П. Батбаярын 2 дэлгүүрийн барилгын төсөл, мөн сумын ЗДТГ-ын барилга, Гурван булаг сумын иргэн Д. Бадарчийн “Тосгон” худаг сэргээн засварлах төсөл, Галуут сумын иргэн Х.Сарантуяагийн “ Нөөц Бэлчээр – 2009” 3 га талбай хаших төсөл, мөн сумын иргэн соёлын төвийг засварлах “Соёлын орчин” төсөл, Баянлиг сумын иргэн Ц.

Бийбатын 1 га бэлчээр хаших “ Нутгийн шим” төсөл зэрэг 91 төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгээд байна.

/Хэрэгжилт-50%/

Засаглал, эрх зүйн шинэчлэл

21.1. Хууль тогтоомж хоорондын зөрчлийг арилгах, уялдаа холбоог сайжруулах ажлын хүрээнд 2009 онд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хөдөлмөрийн тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай зэрэг хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах талаарх саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан.

/Хэрэгжилт-30%/

21.6. “Төр, захиргааны алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлье” сэдэвт сахилга хариуцлагын зөвлөгөөнийг зохион байгуулж ажлын төлөвлөгөө гарган биелэлт, үр дүнг нь тооцон ажиллаж байна. Төр, захиргаа, хууль хяналтын байгууллагуудын ажлын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн Аймгийн Засаг даргын захирамжийг 3 удаа гаргаж хэрэгжилт, үр дүнг тооцон ажиллав.

-2006-2008 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн нөхцөл байдалд судалгаа дүгнэлт хийн нөлөөлж буй хүчин зүйл, шалтгаан, нөхцлийг тогтоож, үүний үндсэн дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын 18 заалт бүхий ажлын төлөвлөгөөг гарган аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан ажилласан. Уг ажилд 16760.0 мянган төгрөг төсөвлөсөнөөс 2009 оны төсвийн тодотголоор 14080,0 мянган төгрөг хасагдаж 2680.0 мян/төг-ийг зарцуулан ажиллалаа.

-Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Галуут сумыг жишиг сум болгохоор шийдвэрлэн, 3 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд Галуут суманд “Жишиг сум” болох үйл ажиллагааны нээлтийн ажиллагаа, түүнтэй холбогдсон зөвлөгөөн, үзүүлэх сургуулийг хийлээ.Энэ үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга, хууль хяналтын байгууллага болон сумдын удирдлагууд, хэсгийн төлөөлөгч, цагдаа нар оролцож , уриалга, зөвлөмж, зохих шийдвэрийг гарган хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

-Алдуул малын бүртгэл судалгааг аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн асуудал хариуцсан ажилтан дээр төвлөрүүлэн, сумдаас сар болгон алдуул малын мэдээг авч, эрэн сурвалжлах ажлыг тасралтгүй хийж байна.

■Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Баянхонгор хотын хэмжээнд квадратын системээр зохион байгуулах асуудлыг шийдвэрлэснээр 2009.07.01-ний өдрөөс 3 хөдөлгөөнт эргүүлийг Баянхонгор хотын хэмжээнд ажиллуулж байна.

/Хэрэгжилт-30%/

21.7. Хууль сахиулах байгууллагын боловсон хүчний үр чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд:

-Цагдаагийн алба хаагчдад хүний эрхийн тухай цэгц мэдээлэл өгч, тэдний хүний эрхийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Хүний эрхийн Үндэсний комиссын ажлын албаны дарга П.Оюунчимэгийг 11 дүгээр сард урьж ирүүлэн, 3 цагийн сургалтыг зохион байгуулж явуулсан.

Цагдаагийн алба хаагчдаас тус аймгийн төрийн байгууллагууд олон улсын болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулсан 3 удаагийн сургалтад Цагдаагийн хэлтсийн 10 ажилтан; ЦЕГ-аас зохион байгуулсан 5 удаагийн сургалтад тус бүр нэг ажилтныг тус тус оролцуулсан.

Төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдийн “Манлайлал”-ын цуврал сургалтад аймгийн Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурор, Цагдаагийн хэлтсийн дарга нарыг тус тус оролцууллаа.

/Хэрэгжилт-30%/

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ**